

Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

Амьс дугаар ТАВАН ЖИЛ

ТӨВ АЙМГИЙН НАМЫН ХОРОО,
АДХ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ СОНИН.

14 дөх жилдээ
№ 10 (1154)

1962 оны
2 дугаар сарын 19

ДАВАА

Төл бойжуулахад эмэгтэйчүүдийн роль

Манай орны мал сүргийн тоог өсгөж ашиг шимийг нэмэгдүүлэн мал аж ахуйг улам эрчимтэй хөгжүүлэх талаар МАХН-ын 14 их хурлаас дэвшүүлэн тавьсан чухал зорилтыг хэрэгжүүлэхэд төл нэг бүрийг мал болгох явдал шийдвэрлэх ач холбогдолтой билээ.

Тус аймгийн ХАА-н нэгдлийн хөдөлмөрийн чадвартай бүх гишүүдийн 41 хувийг эзэлж байгаа эмэгтэйчүүд 1962 онд төрөл бүрийн малын төлийг гаргалзгүй бойжуулахад асар их үүрэг гүйцэтгэх ёстой.

1961 онд манай аймгийн малчин эмэгтэйчүүдийн идэвхтэй ажиллагааны дүнд хүлээн авсан төлийн 96,4 хувийг бойжуулсны дотор 110 хониноос 110 хурга, 20 ямаанаас 20 ишгийг хөрвийн аргаар бойжуулсан.

Баянзүрх сумын хоньчин БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат Сандуй, 185 эм хониноос 186 хурга, 50 ямаанаас 56 ишиг бойжуулсан Бүрэн сумын 3 дугаар бригадын хоньчин Ичинноров, 80 ингнээс 80 богто бойжуулсан Сэрэлэн сумын Авдархангай нэгдлийн эмэгчин Чинэд, 49 ямаанаас 55 ишиг бойжуулсан Хэрлэнбаян нэгдлийн ямаачин Сумъяа нарын зэрэг тэргүүний төлчин эмэгтэйчүүд олон байна.

Одоо ч гэсэн малын төл хүлээн авах бэлтгэл ажилд аймгийн төв суурин газар сууж байгаа эмэгтэйчүүд идэвхтэй оролцож өөрсдийн хүчээр 185 тонн өвс, хужир, шүү 258 тонн, бууд 195 тонныг татаж элгэвч 2252, уут 109, өзмөө 1415, угж 437, төлийн пайз 26 мянган, бөөлий 567, малын хорооны хялх 322, лаа, шүдээ 5270 толгойг нэгдлүүдэд тусалжээ.

Мөнгөнморьт, Баянзүрх зэрэг сумдын эмэгтэйчүүдийн зөвлөл гарын төл болгоныг мал болгох талаар эмэгтэйчүүдийн дунд их ажил хийж байна.

Гэтэл Тариат, Эрдэнэсант, Эрдэнэ, Баянзүрх зэрэг сум-нэгдлийн мал өвөлжинт, төл хүлээн авах бэлтгэл, гарсан төлийг бүрэн бойжуулах талаар эмэгтэйчүүдийн байгууллагуудад тодорхой зохиосон ажилгүй бөгөөд дэргэдэх намын байгууллагууд нь энэ ажлыг бие-тэй удирдлагаар хангахгүй байна.

Иймэрхүү санаа амарлангүй байдлыг өшөө болгож, төл бүрийг мал болгохын төлөө нийт эмэгтэйчүүдийн хүчийг эрчимтэй зохион байгуулан төдний идэвхийг жигд өргүүлэх явдал эмэгтэйчүүдийн бай-

гууллаагын өмнө эрхэм зорилт болон тавигдаж байна.

Малчин эмэгтэйчүүд нэг бүрт малын төл бойжуулах тухай МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн тогтоол, ХАА-н Яамны болзлыг ойлгуулах ажлыг зохиох нь чухал байна.

Төл бойжуулах ажилд төв суурин газрын хөдөлмөрийн чадвартай, бололцоотой эмэгтэйчүүдийн хүчийг оролцуулан малчин эмэгтэйчүүдийн дунд социалист уралдааныг өргөн дэлгэрүүлж ажлаараа шалгарсан төлчин, малчдын тэргүүний туршлагыг нийтэд өзөмшүүлэх, хөвлөлд нийтлэх, радиогоор нэвтрүүлэх олон хэлбэрийг дүүрэн ашиглах хэрэгтэй.

Хургыг хөрөвжилтийн үе шатаар, тугалыг заядуулан бойжуулах шинжлэх ухааны аргыг амьдралд жинхэнэ ёсоор нэвтрүүлэх зорилгоор эмэгтэйчүүдийг энэ ажилд сургавал зохино.

Малын төлдөх байрыг тохилго дулаан байлгах төл, өх малд өгөх тэжээлийг хувиартай ашиглан малдаа билчээх хотлуулах цагийг нарийн баримталж, арчилгаа, мааллагаа сайжруулж хот хорооныхоо ариун цэврийг өрхмөлөн сахих явдал малчин эмэгтэйчүүдийн анхаарлын төвд байх ёстой.

Бие бялдраар бага, туранхай муу төлд биений өсөргүүдийг сайжруулах, элдэв өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор шилмүүсийн ханд, хиймэл уураг, сүү, эмийн ургамал зэргийг эмч нарын зөвлөгөөнөөр бэлтгэж өгөх нь эмэгтэйчүүдийн биечлэн гүйцэтгэвэл зохих хамгийн нарийн ажлын нэг мөн.

Төв орон нутгийн эмэгтэйчүүдээс энэ зорилтоо биелүүлэхэд нь чиглүүлэн тодорхой удирдлагаар хангах нь намын байгууллагуудын чухал зорилт болж байна.

1962 онг мал өсгөх эргэлтийн он болгох асуудлыг шийдвэрлэх хүчин зүйл бол гарсан төл болгохыг мал болгох явдал юм.

Энэ дайчин зорилтыг биелүүлэхэд манай малчин эмэгтэйчүүдийн бүтээл ажиллагаанаас шууд шалтгаална.

Хуудлаа бэлтгэлийн төлөвлөгөө биелүүлэхэд УЭ-ийн гишүүдийг дайчлаж 1000 кг яс, 300 кг техникний тос, 200 кг гуял зэс цуглуулж бэлтгэлд нийлүүлэв.

Польшийн Ажилчны Нэгдсэн Нам байгуулагдсаны 20 жилийн ойн тухай гэрэл зургийн үзэсгэлэнг нээж нөхөр Рагчаагийн хэлсэн үг

НӨХӨД ӨӨ!

Польшийн ажилчин анги, хөдөлмөрчдийн шалгарсан манлай отряд Польшийн Ажилчны Нэгдсэн Нам, үндэслэн байгуулагдсаны 20 жилийн ойн тухай үзэсгэлэнг Намын Төв Хорооны шийдвэрээр тус аймагт өнөөдөр бид нээж байна.

Үзэсгэлэнгийн энэ нээлтэнд оролцохоор ирсэн БНПАУ-ын элчин сайд эрхэм хүндэт нөхөр Стаислав Ткачов, элчин сайдын яамны бусад ажилтан хүмүүст тус аймгийн Намын Хороо, намын бүх гишүүд, хөдөлмөрчдийн өмнөөс чин сэтгэлийн хадуун баяр хүргэе.

Тус аймагт байгуулагдаж байгаа энэ үзэсгэлэн бол олон улсын коммунист хөдөлгөөний дайчин отряд нэг Польшийн Ажилчны Нэгдсэн Намын туульж ирсэн баатарлаг тэмцэл, үйл ажиллагаатай манай хөдөлмөрчдийг танилцуулах юм.

Энэ үзэсгэлэн бол пролетарийн интернационализмын зарчимд бат тулгуурласан манай хоёр орны нам, Монгол-Польшийн ард түмний ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагааг улам хөгжүүлэн бэхжүүлэхэд үзэмжийн ач холбогдолтой юм.

БНПАУ бол социалист лагерийн хамтын ажиллагаа, нэгдэл нягтралыг улам бататгах тэмцэлд үнэнч шударгаар мэрийн ажиллаж, социалист системийг батлан хамгаалах, энх тайвнаар зэрэгцэн орших зарчмыг биелүүлэх хэрэгт хувь нэмрээ оруулж байгаад Монголын ард түмэн чин сэтгэлээсээ баяраар бахархаж байна.

Польш ард улс, эрх чөлөөгөө байлдан авч тусгаар тогтнон хөгжиж буй 17 жилийн дотор ажилчны намынхаа жодоолдоогоор улс ардын аж ахуй, соёлын социалист

байгууламтанд аргаа лут амжилт олж, хөдөө аж ахуйн хоцрогдсон орныг хүчирхэг аж үйлдвэрийн орон болгосныг бид сайн мэддэг юм.

Тус хоёр орон, түүний намын хооронд найрамдалт харилцаа тогтон бэхжиж манай улсын социалист байгууламтанд БНПАУ, ПАНН багагүй туслалцааг үзүүлж ирсэн ба одоо ч үзүүдсээр байгаад бид гүнээ талархаж байдаг юм.

БНПАУ-ын ард түмэн, манай аймгийн Баян сумын нэгдлийн шеф лэн авч «Монгол-Польшийн найрамдал» нэрэмжит болгон аж ахуйн талаар бэхжүүлж социалист том аж ахуй болгоход нь ихээхэн дэмжлэг үзүүлж байна.

Энэ бол зөвхөн аж ахуйн хүрээний асуудал биш манай хоёр нам, Монгол-Польшийн ард түмний үнэнч халуун найрамдын шууд нэрлэл мөн.

НӨХӨДӨӨ!

БНПАУ-аас манай улсад ажиллаж байгаа Элчин Сайдын Яам, ПАНН-ын үйл ажиллагаа, баатарлаг тэмцлийг гэрэл зургийн үзэсгэлэнгээр тус аймгийн хөдөлмөрчид, намын гишүүдэд тодорхой танилцуулж байгаад гүнээ талархаж байна.

Эх орондоо социализмыг амжилттай байгуулж энх тайвныг сонор соргоогоор хамгаалан бэхжүүлэх үйл хэрэгтээ улам их амжилт олохыг Польш ард улсын ард түмэнд ерөөе.

Монгол-Польшийн ард түмний найрамдал улам бэхжүүтгэй!

Марксизм-Ленинизм, пролетарийн интернационализмын зарчимд үнэнч манай хоёр намын ах дүүгийн хамтын ажиллагаа улам хөгжин бэхжүүтгэй!

Польшийн Ажилчны Нэгдсэн Намын тухай үзэсгэлэн

Польшийн Ажилчны Нэгдсэн Намын амьдрал тэмцлийг үзүүдсэн гэрэл зургийн үзэсгэлэн 1962 оны 2 дугаар сарын 14-нд аймгийн соёлын ордонд нээгдэв.

Энэ үзэсгэлэн Польшийн ажилчны намын 20 жилийн ойд зориулагджээ.

Тус үзэсгэлэнг аймгийн намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Рагчаа нээж үг хэлэв.

БНПАУ-аас, БНМАУ-д суугаа онц бүрэн эрхт элчин сайд Сатислав Ткачов үзэсгэлэнгийн нээлтэнд зориулан үг хэллээ.

Элчин сайд хэлэхдээ:

Хайрт анд нөхөд өө!

Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооноос энэ үзэсгэлэнг таны аймгийн төвд байгуулахыг зөвшөөрсөнд ПАНН-ын Төв Хорооны өмнөөс баяр талархлаа илэрхийлэе.

Энэ үзэсгэлэн, Польшийн Ажилчны Нэгдсэн Намын амьдрал тэмцлийг харуулж байгаа юм.

ПАНН бол хувьсгалт тэмцэл, дайч тулалданы хүнд бэрх замыг туулан давж, ажилчин ангийн үйл хэргийн төлөө дайчин хувьсгалт тэмцлийг үргэлжлүүлж ирсэн түүхтэй юм.

Манай хоёр нам ах дүү ёсоор хамтран ажиллаж байна.

Манай хоёр орны ард түмний ах дүүгийн найрамдал өдрөөс өдөрт бэхжин зузаарч байна.

БНПАУ, ах дүү БНМАУ-ын социалист байгууламтын үйл хэрэгт хувь нэмрээ оруулж байгаа билээ.

Социализмын ялалт нь социалист лагерийн орнуудын нягт хамтын ажиллагаагүйгээр амжилт олохгүй билээ.

Социалист лагерийн орнууд нягтаар хамтран ажиллаж социализм, коммунизмын ялалтыг хангахаас илүү эрхэм зорилтгүй.

ЗХУКН-ын 22 дугаар их хурлаас баталсан коммунизм байгуулах намын программ нь бид бүхний хүрэх замыг зааж байгаа учраас түүнийг дагаж мөрдөх ёстой.

Польш-Монголын ард түмний найрамдал, хамтын ажиллагаа манлайттай! Даян дэлхийд энх тайвны улам бэхжүүтгэй! гэжгээрөө.

Үзэсгэлэнгийн нээлтэнд Польшийн элчин сайдын яамнаас худалдааны ажилтан С. Чекальский, МАХН-ын Төв Хорооны ажилтан Ялгуу, Гидадд Яамны ажилтан Ишдорж нар оролцов.

Аймгийн намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга н. Рагчаа, улаан туузыг хайчилж үзэсгэлэнг нээхэд олон зуу үзэгчид Польшийн ажилчны намын туульж ирсэн баатарлаг тэмцэлийн замыг харуулсан энэ үзэсгэлэнг сэтгэл багдам үзэцгээлээ.

Энэ үзэсгэлэнг 75 жилийн өмнө

(Төгсгөл нь 4 дүгээр нүүрт)

БҮГД ХУРЛЫН ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЖ БАЙНА

Тариат сумын УЭ хороо, аймгийн УЭ-ийн бүгд хурлын шийдвэрийг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж худалдаа үйлчилгээний ажлыг сайжруулах 45 хөдөөний ажил зохиож

Их хайрханы уулын үйлдвэрийнхэн БИМАУ- ын ҮЭ-ийн VIII их хурлыг угтаж социалист уралдаанд авсан үүрэг

Их Хайрханы уулын үйлдвэрийн хамт олон бид МАХН-ын 14 дүгээр их хурлын түүхт шийдвэрийг удирдлага болгон Монголын ҮЭ-ийн их хурлыг угтаж III таван жилийн төлөвлөгөөний 2 дахь жил 1962 оны эхний хагас жилийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг давуулан биелүүлэхийн тулд Бэрхийн уурхайн хамт олны социалист уралдааны уриалгыг халуунаар хүлээн авч аймгийн бүх үйлдвэр, аж ахуйн газруудыг социалист уралдаанд уриалж дор дурдсан үүргийг өөртөө авах нь:

Үйлдвэрийн төлөвлөгөөг биелүүлэх талаар

1962 оны I, II улиралд 60 хувийн вольфрамыг гаргаж улсад тушаах төлөвлөгөөг 10 хоногийн өмнө 100,5 хувь, уулын бэлтгэл малталт, таварын хүдэр гаргалтын төлөвлөгөөг 101 хувиар тус тус биелүүлнэ.

Хөдөлмөрийн зохион байгуулалтыг сайжруулан үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг хангаж ажилчдын мэргэжлийг дээшлүүлэн тасаг цехийн орон тоог цомтгож цаг ашиглалтыг сайжруулсан үндсэн дээр хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх төлөвлөгөөг 1,5 хувиар давуулан.

Тасаг цехүүдийн бүтээгдэхүүний нэгжид зарцуулах үндсэн, туслах материалыг 0,6 хувиар хэмнэж бүтээгдэхүүний өөрийн өртгийг хямдруулах төлөвлөгөөнөөс 1 хувиар бууруулан.

Бөхөлгөөний мод, өрмийн ган, барилгын материалыг хэмнэж агаарын замыг ашигдалтад оруулж хангалал ашиглах замаар 250 мянган төгрөгийн хэмнэлт гаргана.

Энэ хугацаанд шинэ бүтээл, оновчтой санал, тэргүүний туршлага 30-аас доошгүй үйлдвэрт гарган, нэвтрүүлж 120 мянган төгрөгийн хуримтлал бий болгоно.

6 цагийн ажлыг 3 цагийн дотор багтаан хийж байгаа тэргүүний өрмөлөгч Цэрэлийн туршлагыг уулын цехийн холбогдох мэргэжлийн бүх хүмүүсийн ажилд бүрэн нэвтрүүлнэ.

Техникийн аюулгүйн дүрэм, хөдөлмөр хамгааллын шаардлагыг бүх ажилчдад судлуулан шалгалт авч, аюул ослоос урьдчилан сэргий-

Аймгийн үйлдвэрлэлийн зөвлөлийн тэргүүлэгчид, Их хайрханы уулын үйлдвэрийнхэнээс 1962 оны тэргүүн хагас жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө биелүүлэхээр

тус аймгийн үйлдвэр аж ахуйн газруудыг социалист уралдаанд уриалан үүрэг авсныг дэмжих аймаг, нийтийн хөдөлгөөн болгон тухай тогтоол гаргав.

лэх, уулын цехэд хөдөлмөр хамгааллын буланг байгуулан, хүнд нөхцөлд ажилладаг хүмүүсийн эрүүл мэндийг улирал дутамд үзүүлж байна.

1962-1963 оны өвлийн бэлтгэл түлш, бэхлэгээний модны 50-60 хувийг бэлтгэж бензин шатхууны сарын бэлтгэлтэй байна.

Үйлдвэрийн ажилчдын зусланг бий болгож ажилчдыг цех, СХТ бригадуудыг бригадаар нь нэг зохион байгуулалттай байрлуулах арга хэмжээ авч орон сууцны ашиглалтыг сайжруулан урсгал засварын 65 хувийг хийнэ.

Авто машин ашиглалтын коэффициентийг 80 хувьд хүргэж дугуйн гүйлтийг 50 мянган км болгож дунд, их засварын хугацааг уртасгаж 100 км дутамд зарцуулах бензиний 0,5 хувиар хэмнэнэ.

Соёл ахуйн талаар

Социалист хөдөлмөрийн бригадын хөдөлгөөнийг дэмжин өрнүүлж 3 бригадын цол мандаат авахуулан, 3 цех тасгийг социалист хөдөлмөрийн төлөө цех болгоно.

Социалист хөдөлмөрийн бригад, төлөө бригадуудын гэрийн цэцэрлэгийг улам тохижуулан, 50-аас доошгүй ортой ажилуулж зарим бригадуудад нэгдсэн гал зуух бий болгоно.

Үйлдвэрийн районьг тохижуулахын тулд 60 ширхэг мод тарьж 500 хавтгай дөрвөлжин метр талбайг зүлэгжүүлэн түүний дунд усан оргилыг бий болгоно.

Үйлдвэрийн хамт олны хүчээр туршлагын журмаар нэг га газар идэшний төрөл бүрийн ногоо тарьж ашиглана.

18-35 насны бүх ажилчдын 70-аас доошгүй хувиар хөдөлмөр батлан хамгаалахад бэлхэн тэмдгийн I, II нормыг хангуулсан байна.

Зэргэлдээ сум-нэгдэл, аймгийн тэргүүний шатарчин, гар ба одон бөмбөг, хүчит бөх зэрэг тамирчиндтай уулзах уулзалтыг уурхайн төвд 1 удаа зохино.

Их Хайрханы оргил булаандалдах тэмцээнийг тасаг, цехүүдийн хооронд 1 удаа зохино. Мэргэжлийн дугуйлагчийн чанарыг сайжруу-

лан I ажилчин 2-3 төрлийн мэргэжил эзэвших хөдөлгөөнийг өрнүүлж 30 хүнд мэргэжлийн зэрэг шинээр олгуула. Соёлын довтолгооны үндсэн зорилтыг ширхэгчлэн биелүүлж бичиг үсэг үл мэдэгчдийг энэ хугацаанд бичигтэн болгож айл өрх, үйлдвэрийн дотоод, гадаад ариун цэврийг сайжруулан хэвийн ажиллагаатай байлгана. Уралдаанд хугацаанд гэмт хэрэг нэгийг ч гаргуулахгүй, үйлдвэр, цех, тасгаараа гэмт хэрэггүй тасаг, цех болгохын төлөө ажиллана.

Клубын зөвлөлийн ажлыг тогтмолжуулж үйлдвэрийн амьдралтай холбогдсон жижиг үзэгдэл, шог гараа, утгачилсан концерт боловсруулан Төв, Дундговь аймгийн төв, зэргэлдээ сум-нэгдэл, бригадуудад тоглуулан үйлдвэрээ сурталчлах ажлыг зохино.

Ажилчдын хүчээр биеийн тамирыг талбай байгуулж ашиглалтад оруулж үйлдвэрийн төвд радио үзэлийг шинээр байгуулан цехүүдийн хооронд угсан харицаатай болно.

Энэ хугацаанд дэлгүүр, халуун ус, талхны газар, материалын агуулах, 16 айлын орон сууц, тус бүр нэг, 8 айлын орон сууц 2-ыг барьж ашиглалтад оруула. Зэргэлдээ сум-нэгдэлд мал төлөлийн үеэр төлийн нэмнээ 400, мал урлахад зориулан худгийн гар насос нэгийг хаядал ашиглан хийж туслана.

Өнжүүл, Баянбараат сумын тэргүүний хүмүүсийг урьж өөрийн үйлдвэрийг сурталчлах, туршлага солилцох ажлыг нэг удаа зохиохын хамт зэргэлдээ орон нутгийн ҮЭ-ийн байгууллагын идэвхтнүүдийн туршлага солилцох зөвлөдгөөнийг БИМАУ-ын ҮЭ-ийн VIII их хурлын түүхт шийдвэрийг биелүүлэх үндсэн дээр 1 удаа явуула. Их Хайрханы уулын үйлдвэрийн хамт олон бид социалист уралдаанд авсан энэ үүргээ биелүүлэх зорилт хүч, төгөлдөр байгаагаа илэрхийлж аймгийн үйлдвэр, аж ахуйн газруудын хамт олныг социалист уралдаанд уриалж байна.

Их Хайрханы уурхайн хамт олныг төлөөлж

Уулын үйлдвэрийн дарга	Мижид
Намын үүрийн нарийн бичгийн дарга	Цэнд
ҮЭ-ийн хорооны дарга	Чойжил
ХЗЗ-ийн үүрийн дарга	Жамсран
Уурхайн цехийн дарга	Осор
Уулын инженер	Цэрэндорж
СХТБ-ын ахлагч	Намхайноров
Уурхайн өрмөдөгч	Цэрэл
Уулын мастер	Мөнхбаяр
Баяжуулах фабрикийн мастер	Жумдаан

ЦӨЦГИЙН ТӨС ҮЙЛДВЭРЛЭХ БЭЛТГЭЛИЙГ ШУУРХАЙ ХАНГАЯ

Ер нь завод тасгийн бэлтгэл ажлыг зөвхөн түлээ, гэр орон, сав суулга бэлтгэх зэргээр хязгаарахад үнээг саалинд бэлтгэх ажлыг анхаардаггүй гэмтйг аргаар цаг болжээ. 1961 онд завод тасгийн бэлтгэлийг хангах ажлыг аймгийн хүнсний комбинат муу удирдсаныг тэмдэглэх хэрэгтэй.

1962 онд аймгийн хэмжээгээр 8200 мянган литр сүү бэлтгэж 3029 мянган литр сүүгээр 100 тонн цөцгийн тос үйлдвэрлэж 5171 мянган литр сүүг Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн хэрэгцээнд нийлүүлэх юм. Үүний бэлтгэл ажлыг шуурхай хийх явдал хойшлуулшгүй чухал зорилт болж байна.

Үнээний хээлийг сайн хамгаалж нэмэгдэл тэжээл өгч үнээний сүүний гарцыг нэмэгдүүлж байгаа тэргүүний туршлагыг саалийн бүрийн ажиллагаанд нэвтрүүлж тасаг, заводын хэрэгцээт түүнийг 4 дүгээр сарын I-ий бүрэн хангаж модыг хөрөөдөх, аргамыг тасаг байрлах газар буулган, бөрөөнөөс хамгаалах хэрэгтэй.

Тасгийн гэр, заводын барилгын засварыг 5 дугаар сарын I-ий дотор хийж, ариун цэвэр шинжилгөөний хэрэгсэлүүдийг тасаг завод

бүрд хэрэглэгдэх хэмжээгээр бэлтгэж зохих.

Сүүний машин, сав, битон зэргийг 3 дугаар сарын 10-ны дотор засварлан, тослог тасаг тус бүрээр нь тусгаарлан бэлтгэх нь чухал. Тасаг заводад он удаан жил идэвх зүтгэлтэй ажиллаж байсан тэргүүний хүмүүсийг ажиллуулах нь сүүн үйлдэхүүний техниклогийн шаардлагыг ханган биелүүлэхэд маш их ач холбогдолтой байна.

Тасаг заводын бэлтгэл ажлыг тохилог сайн хангахад залуучууд, үйлдвэрчдийн эвлэл, эмэгтэйчүүд зэрэг олон нийтийн байгууллагууд ажил төрлийн тодорхой тусалцаа үзүүрэхийн хамт аймгийн хүнсний комбинат биелэн туслах, зохион байгуулалтын тодорхой удирдлагаар хангах ёстой.

Завод тасгийн бэлтгэл, ажиллах хүчээр хангах ажлыг 5 дугаар сарын I ний маана бүрэн гүйцэтгэж 1962 оны цөцгийн тос үйлдвэрлэх төлөвлөгөөг хугацааны нь урьд давуулан биелүүлэх нь орон нутгийн намын үүр, хороо, захиргааны удирдлага, хүнсний үйлдвэрийн мэргэжилтэн, заводын мастеруудын өрхөм чухал зорилт мөн.

Б. Хумуу.

Техникчид, төлчиддөө туслав

ХАА-н яамны харьяа Архустай дахь ХАА-н техникчдийг бэлтгэх сургуулийн комбинатын багш, ажилчид тус сангийн аж ахуйн хөдөлгөөн 2 дугаар фермийг 1961 онд шөфлэвч төлийн бэлтгэл, хүн хүчний байнгын тусалцаа үзүүлж иржээ.

Тус сургуулийн хамт олон энэ жил шөф фермдээ хурганы уут 32, угж 62, элгэвч 1400, пайз 8000, гаапуу 26, хүрз 16, халаа 20-ийг хийж тусалснаас гадна бие хүмүүс очиж хашаа 2-ыг шинээр барьж 2-ыг засварлаж өгчээ.

Тус фермийн суурь бүрийг сургуулийн комбинатын ангиуд шөфлэн авч захидаа бичих, лозун, дарцаг, ухуулах хуудас хийж явуулдаг байна.

Ингэж ажилласнаар тус фермийн суурь бүр элгэвч 50, пайз 500, уут 2, угж 3-4 тэй болж гарсан төл бүрийг мал болгож аврага төлчний болзол хангахаар бүхмалчдын бүтөөлч идэвх өрнөж байна.

Д. Чулуун.


1961 онд цөцгийн тос үйлдвэрлэх төлөвлөгөөг аймгийн хэмжээгээр 101 хувиар биелүүлж 1 кг тосонд зарцуулах сүүний нормыг 0,3 литрээр хэмнэж уг хэмнэсэн сүүгээр 2,1 тонн цөцгийн тос үйлдвэрлэсэн билээ.

Бэлтгэл хугацаанд нь доринтой сайн хангасан Баян, Заамар, Өндөр ширээт, Эрдэнэсаят сумын заводууд тос үйлдвэрлэх төлөвлөгөөг 1961 онд 101,2-116,8 хувиар биелүүлж 1 кг тосонд зарцуулах сүүг Баян сумын завод 1,5 литр, Баянуулам завод 1,7 литрээр хэмнэжээ.

Гэрч өнгөрсөн онд сүү хүлээн авч цөцгийн тос үйлдвэрлэх бэлтгэл ажлыг муу хийснээс болж бүх сум-нэгдлийн 84,7 хувь буюу 22 сум-нэгдэл улсад тушаах сүүний төлөвлөгөөг тасалсны дотор Баянцогт 56 хувь, Баянчандмань сум 47,4 хувь, Алтанбулаг сум 49 хувиар тус тус тасалжээ.

Аймгийн хэмжээгээр бэлтгэж чадаагүй 2833,7 мянган литр сүүгээр зөвхөн цөцгийн тос үйлдвэрлэсэн бол даруй 134,9 тонн тос үйлдвэрлэж, үүнээс гарсан пактаар чихэртэй ариунд 100 тонн бэлтгэж болох байв.

Нөгөө талаар ихэнх нэгдэл үнээний хээтүүлэг, хөөл хамгаалах ажлыг муу зохион байгуулснаас үнээ сувабрах явдал их байв.



малчдад зөвлөлтөө

Төллөлтийн хүндрэлтэнд үзүүлэх тусламж

Хэвийн байдалд төлөж байгаа мал хүний ямарч тусламж шаардахгүй.

Төллөлт хэтэрхий удааширвал тусламж үзүүлэх хэрэгтэй. Иймд төрөл бүрийн мал хэвийн байдалтай төлөхөд хэрэглэгдэх хугацааг мэдэх нь чухал.

Төл нь цухуйснаас хойш үнээ 20 минутаас 6 цаг (дунджаар 3 цаг), гүү 5-30 минут, хонь, ямаа 5-30 минутын дотор тус тус төлөх бөгөөд үнээ 6-8 цаг, гүү 5-30 минут, хонь, ямаа 10 минутаас цагийн дотор хаг нь унадаг.

Дурдсан хугацаанаас хэтэрвэл хэвийн бус төллөлт бөгөөд хаг нь саатсан гэж үзнэ.

Мал төлөж чадахгүйд хүрвэл малын эмчид мэдэгдэх хэрэгтэй.

Гөвч малчид өөрсдөө тусламж үзүүлэхэд хүрвэл юуны өмнө анхаарвал зохих хэдэн зүйл бий. Үүнд:

Тусламж үзүүлэх гэж байгаа хүн цэвэр халааз өмсөж ханцуйгаа сайн шамлаж, хумсаа авсны дараагаар гараа савантай бүлээн усаар сайн угаана.

Хумсны завсар, хурууны үзүүрийг йод буюу марганцтай усаар ариутгана.

Үүний дараагаар саван, вазлины аль нэгийг гартаа түрхэж, гарах гэж байгаа төлийн цухуйсан хөл, толгойноос нь зугуухан доош дэлэн рүү нь чиглүүлэн малын дүлэгтэд тохируулан татна.

Зөв байрлалтаар гарч байгаа

төл бол урьд 2 хөл дээрээ. хушуугаа тавьсан байдалтай байдаг.

Хэрэв 1 хөл нь цухуйх, өсгүү толгой нь гарсан боловч хөл нь далд, 2 хөл нь гарсан боловч толгой нь далд байх зэргээр төлийн байрлалтын буруу байгаагийн шинж тэмдэг мэдэгдэнэ.

Энэ үед төлийг хүчээр татаж гаргах гэсний хэрэггүй.

Харин төлийн байрлалтын эвс бурууг сайтар ажиглан олох нь чухал.

Үүний тулд төлийн цухуйсан хэсгийг буцаан оруулж, гараа дахин угааж цэвэрлэсний дараа төлийн хажуугаар гараа оруулж байрлалтыг дотор нь засаад зөөлөн татаж гаргана.

Үүний дараа 1 литр усанд 1 грамм марганц хийж савы нь угааж цэвэрлэх нь асар их ач холбогдолтой.

Дараа нь тусламж үзүүлсэн хүн гараа савантай бүлээн усаар сайн угааж спирт буюу марганцын уусмалаар цэвэрлэх хэрэгтэй.

Төллөсөн малыг бүлээн усаар услаж, асперин буюу натасолицилийг 5 граммээр өгч болно.

Гарахгүй байгаа төлийг учиргүй татаж чангааж гаргавал малын үмийг урж гэмтээх аюултай.

Төрөлт нь хүндрэхэд төлийг гаргаж чадахгүй хүн зүй бусаар оролдвол цаг алдаж улам хүндрүүлэн эх малыг үхүүлэхэд хүргэнэ гэдгийг анхаарах хэргтэй.

малын их эмч Тэгшдүүрэн

784 хонь төллүүлнэ

Жаргалантын сангийн аж ахуйн 10 жилийн дунд сургуулийн захиргаа, мал төллөлтийн үеийг тохиолдуулан Самбуу-Видон ахлагчтай хонины суурийг шөвлөн авч, 2 багш, 10 сурагч цанаар 30 гаруй км газар аялан, очсон оройгоо сурагчид тэр суу, ийнхэд луу дуулж, шүлэг уншиж олон төрлийн сонирхолтой яриа хийж 146 өлгөч, 10 уут, 8 нэмнэ, 10 угж, лаа, шүдэн бэлгэлжээ.

Маргааш өдөр нь сурагчид 200 хурга багтах нүд 1-ийг барьж, 30 орчим тэрэг хог зөөж, хотны хөрвөн ховхдох ажил хийлээ.

Суурийн ахлагч Самбуу-Видон гуай, САА-д 9 жил хонь хариуца төлийн нь бүрэн бойжуулдаг туршлагатай малчин юм.

Би өнгөрсөн жил хариуцсан минийхээ төлийг 102 хувир байжуулсан, ер нь төл байжуулах ажил ч ойрын хэдэн жил тун ургантай сайн байна.

Энэ жил ч гэсэн гарсан төлөө ганц ч хорогдолгүй байжуулж авна гэж бүх хүчээ дайлаж байна.

Бид 1962 онд 784 хонь төллүүлнэ. Одоо 11 хонь төлөснөөс 1 хонь ихэрлээд 12 хургатай болон.

Би лав 785 хурга мал болгоно гэж бодож байна.

Харин дахиад хэдэн хонь ихэрлэхийг мөдөхгүй, хэрэв ихэр гарвал

үүнээс илүү төл хүлээн авч бойжуулах болно гэж сэтгэл хангалуун ярих.

Б. Дамдинсүрэн



Өндөрширээт сумын Хөгжлийн зам нэгдлийн жинчин Цэдэвсүрэн, Рэнцэнбат нар тэмээгээр хол ойрын тээвэр хийхдээ их дадлагатуршлагатай болсон хүмүүс юм.

Энэ хоёр жинчин 25 тэмээ хариуцан эдэлж сүүлийн 3 сард өвс 35 тонн, хужир шүү 26 тонн

Эрүүлийг Хамгаалах Яам, эмч нараар бүрдсэн эрүүл энхийн сурталчлан туслах бригадыг шөф Бүрэндэлгэрэх нэгдэлд ирүүлж 10 хоног ажиллуулав.

Энэ туслах бригадынхан сумын төвөөс алсагдсан бригад суурийн малчдаар явж төдий эрүүл мэндийг үзэж сумын төв хөдөөд 550 гаруй хүн үзэж эмчилж, нэгдлийн гишүүдийг гэрийн аптектай болгож ойр зуурын хэргцээний 500 гаруй төгрөгийн эмийг үнэгүй өгөв.

Сумын төвийн соёл үйлчилгээний болон албан газруудад биечлэн явж соёл ахуйн ба ариун цэврийн шаардлагыг хангах соёлын довтолгооноор тавигдсан зорилтыг биечлэхэд биечлэн туслав.

Улаан загаламй нийгэмлэгийн үүрийн ажилтай танилцаж зааваалан, нийгэмлэгийн гишүүдээр "Эрүүл энхийн эргүүл" нөхөрлөлийг байгуулан улаан загаламй нийгэмлэгийн зорилгыг сумын хөдөлмөрдөд өргөн сурталчилснаар 7 хоногийн дотор үүрийн гишүүдийн тоо 2 дахин нэмэгдлээ.

Мөн бригадын гишүүдээс Монголын улаан загаламй нийгэмлэгийн үйл амьдралыг харуулсан самбар хийж тавилаа.

Сурталчлан туслах энэ бригад сумын төвийн хөдөлмөрдөд хүүхдийн хүмүүжил, өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай, эмэгтэйчүү-

дийн эрүүл ахуй, хүний эрүүл энхэд хоол тэжээлийн ач холбогдол, малаас хүнд дамжин халдварлаж болох өвчнөөс сэргийлэх тухай зэрэг энх аж төрж амьдрахын тухай анагаах ухааны ач холбогдолтой чухал сэдвүүдээр 8 удаа 1100 хүнд таниулга хийжээ.

Хүмүүсийн урт удаан наслах энх аж төрөхтэй холбогдсон 18 төрлийн санамж, ухуулах хуудас, хялбарчилсан сэдвүүдийг айл өрх, албан газруудад өгөв.

Манай шөф Эрүүлийг Хамгаалах Яамны нэм, эвлэл, олон нийтийн байгууллагын ажилтан, ажилчаас малын төл хүлээн авахад зориулж уут, нэмнээ, угж, элгэвч, лаа, шүдэн зэрэг 2000 гаруй ширхэг зүйлийг нэгдэлд тусалжээ.

Төлийн эм антибиотек, Стрептомицин 20 авдар зэрэг, бүгд 150-аад мянган төгрөгийн материалын тусалцаа үзүүлжээ.

Шөфийн байгууллагын энэ тусалцаа нь хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүд биднээс мал сүргээ онд оруулах, төлийн бэлтгэлийг хангаж, гарсан төлөө бүрэн бойжуулан 1962 онд малаа төрөл бүрдээр нь өсгөхөөр улам шинэ хүч зориг нэмэгдүүлж байна.

Бүрэн сумын нэгдлийн үүрийн нарийн бичгийн дарга Л. Жамсран

Дахин туслав

БНМАУ-ын Бичгийн ерөнхий хорооны дарга н. Лхамсүрэн орлогчийнхоо хамт өөрийн шөф Хэрлэн-баян нэгдэлд очиж нэгдэлчдийн баярыг тохиолдуулан бэлдсэн бэлгэдийнхээ 2 дугаарыг баярчин бичгийн хамт гардуулжээ. н. Лхамсүрэн тус нэгдлийн төлийн бэлтгэлд зориулан хайс 250, тугалын нэм, 20, хурганы уут 34, аптек 400, угж хөхөлтийн хамт 100 ширхгийг бэлгэлж, МАХН-ын Төв Хорооны 11 бүгд хүрлийн материалаас дэлгэрэнгүй яриа, төл болгоноо мал болгож, мал өсгөсөн урьдах туршлагаа улам бататгахыг малчдад уриалав.

Д. Содгом

Харин дахиад хэдэн хонь ихэрлэхийг мөдөхгүй, хэрэв ихэр гарвал

мал төлөх сууриудад тээвэрлэж буулгаад одоо хашааны мод зөөхөөр бэлтгэж байна.

ЗУРАГ ДЭЭР: Жинчин Цэдэвсүрэн, Рэнцэнбат нар өвс тээвэрлэж яваа нь.

зургийг Д. Дондогдорж

Польшийн Ажилчны Нэгдсэн Намын тухай үзэсгэлэн

(Төгсгөл)

Польшийн ажилчны хувьсгалт байгууллага, Польш-Литвийн Социал-Демократ нам гэдэг нэртэй үүсэвчээс хойш ажилчны ангийн хувьсгалт хөдөлгөөнтэй нягт холбоотой тэмцэл хөгжиж ирснийг харуулж байна.

Энэ зөвсөр Польшийн ажилчны хувьсгалт байгууллага, их гарз хохирол үзжээ.

Польшийн эн хамт намын нэртэй зүтгэлтэн Ресалюсбургийг германы цагаатан буудан алжээ.

Гитлерийн яргачид Польшийг эзлэн байх зуураа Польшийн ажилчны намын 50 зүтгэлтнийг нэг дор дүүжлэн алсныг баримтат гэж зургаар харуулсан нь үзэгчдийн зурхийг шинжирүүлж байлаа.

Польшийн Ажилчны Нэгдсэн Нам нь Польшийн ард түмний эрх чөлөөний шийдвэрлэх тулалдааны үед ард түмний тэмцлийг манлайлан Польшийг фашистын боолчлолоос чөлөөлөх, улмаар дайнд сүйдсэн эх орноо бөгино хугацаанд сэргээн босгож социализмыг амжилттай байгуулж байгааг энэ үзэсгэлэн тодорхой харуулж байна.

Гитлерийн зэрлэгүүд Польшийн олон сая хүнийг хядаж, нэгч бүтэн хот, суурин үлдээггүй нь үзэсгэлэнгээс харагдаж байна.

Ингэж сүйдсэн орныг сэргээн босгоод хүчирхэг социалист улс байгуулж амжилттай нэгдсэн намын удирдуулсан баатарлаг ард түмний бүтээлч тэмцлийг зүй ёсоор бэхдүүлж байна.

Дайны өмнө 1938 онд аж үйлдлийн бүтээгдэхүүний гаргалтыг 100 хувь гэж үзвэл 1945 онд 19 хувь болон буурчээ.

1960 онд 338 хувьд хүрснийг хархад маш сайхан байна.

Польшийн Ажилчны Нэгдсэн Нам маш их өсчээ.

1944 онд 20000 гишүүнтэй байсан бол 1948 оны 9 дүгээр сард 1066873 гишүүнтэй болжээ.

Олоо Польш улс социализмыг амжилттай байгуулж байна.

Польшийн социалист байгууллагад Зөвлөлт Холбоот Улс сэтгэл хараамгүй туслаж байгааг үзэсгэлэн харуулж байна.

Энэ үзэсгэлэн, эх дүү Польшийн ард түмний дайчин манлай ажилчны нэгдсэн намын амьдрал тэмцэлтэй манай олон нийтийг танилцуулж байгаагаараа Монгол-Польшийн ард түмний эх дүүгийн найрамдлын баттахад их ач холбогдолтой боллоо.

Үзэсгэлэн үзсэний дараагаар Урьдын ба одоогийн Польш гэдэг кино гарав.

М. Сандуй

ЦАНЫН ТЭМЦЭЭН

Саяхан амралтын нэг өдөр Жаргалантын САА-н 10 жилийн дунд сургуулийн 1962 оны цанын арга шалгаруулах тэмцээн явагдав.

Эрэгтэйчүүдийн 10 км-ийн уралдаанд тамирчдыг гарсны дараа хүмүүс өөр хоорондоо тэр, энэ түрүүлээ гэж хүүрнэн ярихыг сонсоход, эдгээ манай Цагаанхүү ч техниктэй шүү, ялангуяа уруу газар ч гүйцэгдэхгүй шүү гээ.

Эрдэнэ ч мөн тамиртай даа, цунахаа мэдэхгүй хүн шүү гэх зэргээр ярилцана.

Үнэхээр ч эрэгтэйчүүдийн 10 км-ийн уралдааны дүн гарахад улсын II зэргийн тамирчин Цагаанхүү 44,5 минут хурдаж 1 дүгээр байр, Эрдэнэ 45,2 минут хурдаж 2 дүгээр байр эзэллээ.

Эрэгтэйчүүдийн 5 км-ийн зайн уралдаанд 5 дугаар ангийн сурэгч Пүрэвжал 25 минут гүйж 1 дүгээр байр, дараах байруудыг сурэгч Ганболд, Баасанжав нар эзлэв.

Эмэгтэйчүүдийн 3 км-ийн зайн уралдаанд 6 дугаар ангийн сурэгч Дашивэрэн 19,8 минут хурдаж 1 дүгээр байр, Бадарч 20 минут хурдаж 2 дугаар байр эзлэв.

Тэмцээний нийлбэр дүнгээс үзэхэд тамирчин: Цагаанхүү, Пүрэвжал, Дашивэрэн нар тус сургуулийн 1962 оны цанын арга болгоов.

Аюурзана

Батсүмбэрт

Батсүмбэрийн сангийн аж ахуйн авто ба хөдөө аж ахуйн гараашийн 20 гаруй ажилчид нэгдэлчдийн сайн өдрийг тохиолдуулж аж ахуйнхаа Ала-

тау 25 буханд хаваржих хашаа барьж, хаягдал сүрэл түүж хэвтрий нь зузаалжээ.

Ж. Дэмбэрэлорж

Хөдөлмөрдийн захидалас

ОТӨРЧДЫНХОО ХОЙНООС АНХААР

Баяндэлгэр сумын Хэрлэнбаян нэгдлийн 2 дугаар бригадын Давалкерэн, Цэгмэд, Гомбосүрэн, Гомбо нарын хэсэг өтөрчид 1300 гаруй үхэртэй долоон суурь болон Хэрлэн Баян-улаанд өнтэй тарган өвөлжөөд хаваржих байна.

Харин энэ өтөрчид тэнд бусад сум-нидлээс зохсон байгуулсан ухуулах бригадыг сонирхон үзэж худалдааны агент, хүн, малын эмч нарыг үйлдүүлээгүй бол үлэмж гачигдах байжээ.

Баяндэлгэр сумын удирдагууд бөрийн спорт гарсан малчдыг үйлч-

лэх агент, малын семитар, бригадын зөвлөл зэргийг нутагтаа авч үлдчихээд сэтгэл нь зовохгүй суудаг байна.

Тэнд энэ сумын нам амьлалын ухуулагчгүйгээс 1962 оны хөдөлгөөс нэгийг ч олж үзээгүй.

Малчдыг ингэж ганд нь орхин байгаа явдалдаа Баяндэлгэр сумын намын үүр, сумын АДХГ захиргааны удирдагууд дүгээт хийж шийдвэртэй арга хэмжээ авах ёстой.

Ш. Базарсод

«Анхдугаар таван жил» сонин газар хэвлэв.

Зөвлөлгөөн үр дүнтэй болов

Сэлэнгэ аймгийн төвд саяхан Ховсгод, Төв, Сэлэнгэ аймгийн сургуулиудын хэлбичгийн багш нарын зөвлөлгөөн болж өнгөрөв.

Энэ зөвлөлгөөнд хэлбичгийн дэд дархны, гавъяат багш Дэлхжав, багш нарын мэрэгжил дээшлүүлэх институтын хэлбичгийн танхимын эргэлтч Өлзийхутаг нар оролцов.

Зөвлөлгөөнд 8 дугаар ангид үүдлэрийн хүй заахад авчирч зүйт үгийн зүйтэй хэрхэн холбох тухай Сэлэнгэ аймгийн төвийн 10 жилийн дунд сургуулийн багш Чойжил, 5-7 дугаар ангид утга зохиолын хичээл явуулах тухай Зүүнхарагагийн сургуулийн багш Нанзад, сургуулийн ханын хэвлэл ямар байх тухай Сэлэнгэ аймгийн зөвлөлийн хорооны хөд дугаар нарийн бичгийн дарга Товууч нарын 10 гаруй нэгтгэл тавигдаа.

Багш Чойжил, хичээл заахдаа хичээлд холбогдсон үгүүлбэрүүдийг орон нутгийн амьдрал, уран зохиолын ном хэвлэлээс авч самбарт бичээд холбогдох дүрмийг сурагчдаар гаргуулдаг нь сурагчдын идэвхийг ихэд өрнүүлж, төсөөлөн бодолтыг ихэсгэж сурагч бүхэн шинэ хичээлийн дүрмийг гаргахыг хичээдэг болжээ.

Багш Чойжил хичээлийг сурах номоор хязгаарладаггүй энэ дүрмд тохирч байна уу? үгүй юу гэдэгт зохих ёсны судалгаа, дүгнэлт хийж заадаг байна.

Багш Нанзад утга зохиолын хичээл заахдаа харилцан ярианы аргыг тайлбарлан, самбараа 2 хувааж зураад, сайн талын баатар, муу талын баатарыг ялгаж бичээд, баатаруудын дүрийн ялгааг харшуулан ойлгуулааг байна.

Урьдах хичээлийг давтахдаа ямар нэг зохиолоос шинэ авч өөрөө хэлж энэ ямар зохиол гардаг вэ? гэж асуугаад сурагчдаар яриулбал сурагчдын идэвх сэргэдэг юм гэж

арилаа. БНМАУ-ын гавъяат багш Дэлхжав хэлэхдээ:

Багш хичээлийг заахдаа сэдвийн хүнд хөнгөтэй нь тохируулж, хичээлийн хэлбэрийг олон янзын аргаар явуулж хичээлээ сурагчдад сөнирхуулахаар заах нь чухал юм.

Багш, сурагчдад сул дун тавих сурагчдыг хүнд байдалд оруулж байгаа хэрэг, сул дун авсан сурагчдыг тэр өдөрт нь давуулаад, маргааш нь асуугаад дахин дүгнэх нь их ашигтай.

Хэрэв өлчтэй байгаад хичээлээс хохорсон сурагчдад нөхөн олгуулах хичээл заах нь чухал байдаг.

Сурагчдын дэвтрийн ажиллагааг цэвэр нямбай байлгаж, уран зохиолыг заахдаа, багш өөрөө үйл явдалд нь орж, сурагчдыг хичээлд хандуулах нь ашигтай гэж зөвлөв.

Багш нарын мэрэгжил дээшлүүлэх институтын хэл бичгийн танхимын эрхлэгч Өлзийхутаг хэлэхдээ: Багш нар, сурагчдын бичгийн алдааг дүгнэхдээ дүрмийн тоогоор биш, алдсан үсгийн тоогоор дүгнэж байх нь ашигтай.

Хэлбичгийн хичээлд багш нарын анхаарах гол зүйл бол сурагчдын алдаагүй, цэвэр нямбай, элементээр бичдэг болгох хэрэгтэйг зөвлөв.

Ойрын үед бичгийн ажлын амтгэл гаргаж дасгалын ажлыг сайжруулах талаар заах аргын туслацаа өгнө гээв.

Энэ зөвлөлгөөн, багш нарын заах арга ажиллагаанд хэрэглүүштэй олон зүйлийг мэдүүлж өгөв.

Ингэж мэрэгжил нэгтэй багш нарын уулзалтууд үе үе хийж байх нь багш нарын сурган хүмүүжүүлэх арга ажиллагаанд асар их үр дүн өгнө.

Б. Лянхуа

Баяндэлгэрт

Сумын төвийн албан хаагчид, тарианы гурсанд өвөлжүүлэхээр үлдээсэн хонины 3 суурьт очиж, бүтэн өдөр ажиллаж, хонины 3 хашааг сэлбэж, хэрвэл ховхлон хашааны хана туургыг өндөрлөж, тусгай тэжээл хонинд халх барьж өгчээ.

★ Сумын төвийн ажилчин, албан хаагчдын хүтээх сүүний заводын хаа 80 кубметрийн багтаамжтай зөөрийг 1 өдөрт багтааж мөслөжээ.

Г. Нямбуу

Шог шүүмн

Сэргэлэн сумын Авдархангай нэгдлийн 3 дугаар бригадын малын бага эмч Дашдэндэв архийг хэмжээгээрээ хөтөртөл багтаад эхнэрээ ингэж зодогчийн нэг болжээ. Эргийн номхон зантай ч гэсэн ажлын цагийг тасалж архи болгож хүмүүсийн тоонд Баяндэлгэрийн сумын худалдаа бөдтгөлийн барааныг ирвэл Лувсанпунцаг, жодооч Дорлоолам, сургуулийн ажилтан Буяндэлгэр, Дэлгэрхааны малын эмч Намнан, 13 дугаар авто баазын жодооч Гочоо нар орж байна.

Архи ууж согтуураад ажлын хариуцлага, сахалга бат гажуудуулж байгаа явдалд удирдах газ-



Д. Дондогдорж

Хариуцлагатай эрхлэгч
С. ДИНСМАА.